

Монгол Улсын Гадаад хэргийн яам Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яаманд хүндэтгэлээ илэрхийлэхийн ялдамд Монгол Улсын Засгийн газар Америкийн иргэдэд виз олгох журмаа дараах байдлаар өөрчилснийг мэдэгдэх завшаан тохиолдов. Энэ шинэ журам нь 2001 оны 7 дугаар сарын 18-ны өдрөөс хүчин төгөлдөр болно.

<u>Визийн ангилал</u>		<u>Хураамж</u>	<u>Зорчих</u>	<u>Хугацаа</u>
а) Дипломат төлөөлөгчийн газрын ажилтан	D	Байхгүй	Олон удаа	36 сар
б) Олон улсын байгууллагын ажилтан	OY	Байхгүй	Олон удаа	36 сар
в) Гадаадын байгууллагын төлөөлөгчийн газар, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн ажилтан	T	Байхгүй	Олон удаа	36 сар
г) Албан хэргээр зорчигч	A	Байхгүй	Виз шаардлагагүй	
д) Хувийн хэргээр зорчигч	H	Байхгүй	Виз шаардлагагүй	
е) Жуулчин	J	Байхгүй	Виз шаардлагагүй	
ё) Суралцагч	S	Байхгүй	Олон удаа	60 сар
ж) Сэтгүүлч	B,H	Байхгүй	Олон удаа	36 сар
з) Гэрээгээр ажиллагч	HG	Байхгүй	Олон удаа	36 сар
и) Цагаачлагч	TS	Байхгүй	Олон удаа	36 сар
й) Бизнес эрхлэгч	B	Байхгүй	Олон удаа	36 сар
к) Төрийн бус болон хүмүүнлэгийн байгууллагын ажилтан	O	Байхгүй	Олон удаа	36 сар

Монгол Улсын Гадаад хэргийн яам энэ завшааныг ашиглан Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яаманд нэн өндөр хүндэтгэлээ дахин илэрхийлж байна.

Улаанбаатар хот,
2001 оны 7 дугаар сарын 6-ны өдөр

**АМЕРИКИЙН НЭГДСЭН УЛСЫН
ЭЛЧИН САЙДЫН ЯАМАНД
Улаанбаатар хот**